

МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2022 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

№	Зорилт /бодлогын үндэслэл/	Төсөл, арга хэмжээ	Үр дүнгийн шалгуур үзүүлэлт		Хэрэгжилт	Хувь
			Суурь түвшин	Зорилтот түвшин		
1	2	3	4	5	6	7
Зорилго 3.7.Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын нэгдмэл удирдлага, менежментийн тогтолцоог бэхжүүлж, иргэдийн орон сууцны хангамжийг нэмэгдүүлнэ.						
3.7.2	МУТЖҮЧ-3.6.4, ЗГҮАХ-3.7.2	Батлан хамгаалах, газар зохион байгуулалт, хот байгуулалт, геологи хайгуул, байгаль орчин, авто зам, төмөр зам зэрэг салбарын эрэлт, хэрэгцээнд нийцүүлэн Монгол Улсын нутаг дэвсгэрийн 55 хувийг 1:25000-ны масштабтай байр зүйн зургаар зурагжуулах	Монгол Улсын нутаг дэвсгэрийн 45 хувь буюу 704000 кв.км талбайг хамрах 7328 хуудас 1:25000-ны масштабтай байр зүйн зургийг агаарын зураглалын аргаар хийж гүйцэтгэсэн.	Монгол Улсын нутаг дэвсгэрийн 55 хувийг 1:25000-ны масштабтай байр зүйн зургаар зурагжуулсан байна.	Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний хүрээнд хэрэгжих төслүүдийн судалгааг бөглөн саналыг 2022.05.19-ний өдрийн 1/884 тоот албан бичгээр БХБЯ-нд хүргүүлсэн. Монгол Улсын нутаг дэвсгэрийн 55 хувийг 1:25000-ны масштабтай байр зүйн зургаар зурагжуулах төсөв, танилцуулга бэлтгэн 2023 оны төсөвт тусгуулахаар 2022.08.02-ны өдөр Сангийн яаманд хүргүүлэв. 2023 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын ажилд шаардлагатай “Боомтыг хөгжүүлэх, шинээр барихаар төлөвлөсөн олон улсын транзит хурдны зам, хилийн боомтуудыг холбох хатуу хучилттай авто замын дагуу GNSS-ийн сүлжээ байгуулах, 1:25 000 масштабтай байр зүйн зураг зохиох” ажлын төсөв, талбайн хэмжээг шинээр гаргаж, танилцуулга бэлтгэн Сангийн яаманд 2022.08.25-ны өдөр хүргүүлэв. Усны газар, Үндэсний геологийн албанд 1:50000-ны масштабын геологийн зураглал, гидрогеологийн дунд масштабын зураглалын ажлыг 1:25000-ны масштабтай байр зүйн зурагт суурилан хийх саналыг, төсвийн тооцооны хамт 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр 1/2129, 1/2131 дугаартай албан бичгээр Барилга, хот байгуулалтын яаманд хүргүүлсэн.	100
3.7.4	МУТЖҮЧ-3.6.3, ЗГҮАХ-3.7.4	Газар ашиглалт, газрын мониторингийн байнгын ажиллагаатай хяналтын системийг бий болгож, газрыг хамгаалах, нөхөн сэргээх тогтолцоог бүрдүүлэн хяналт тавих	Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны мониторингийн 15000 цэг бүхий сүлжээг байгуулсан.	Мониторингийн сүлжээний 3000 цэгт газрын төлөв байдал, чанарын судалгааг хийж, хөрсний хяналт-шинжилгээний улсын 1 лабораторийг Төвийн бүсэд байгуулсан байна.	ГЗБГЗЗГ-аас бэлчээрийн газрын өөрчлөлтийг фотомониторингийн аргаар үнэлэх ажлыг 2022 онд бэлчээрийн газрын мониторингийн 5166 цэг дээр хийж гүйцэтгэсэн ба Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэнгээс бэлчээрийн газрын мониторингийн 1513 цэгийг мэдээг авч нэгтгэн нийт бэлчээрийн газрын мониторингийн 6679 цэгт дүн шинжилгээ хийж, 2022 оны улсын хэмжээний бэлчээрийн газрын төлөв байдлын зургийг боловсруулж нөхөн сэргээх талбайг тодорхойлон санал, дүгнэлтийг аймаг, нийслэлийн Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгуулахаар Нийслэлийн Газар зохион байгуулалтын алба болон 21 аймгийн ГХБХБГ-т хүргүүлсэн. Мөн гарсан үр дүнг Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 1/2132, Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд 1/2121 дугаартай албан бичгээр тус тус хүргүүлэн хамтран ажиллаж байна. Нийслэлийн хот суурины мониторингийн 300 цэгт хийх бохирдлын судалгааны ажлыг Нийслэл, дүүргийн Газар зохион байгуулалтын албатай хамтран хөрсний бохирдлын судалгааг хийж гүйцэтгэн материал боловсруулалтын ажил хийгдэж байна. Тариалангийн газрын мониторингийн 100 цэгт хянан баталгааны ажлыг хийж гүйцэтгэсэн үр дүнг газрын мониторингийн цахим системд оруулахаар ажиллаж байна. Ажлын үр дүнг ашиглан	100

					<p>“Зайнаас тандан судлалын аргаар тариалангийн газрын мониторинг хийх аргачлал”-ын төслийг боловсруулж Даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхээр бэлтгэж байна. Хөрсний хяналт-шинжилгээний лаборатори байгуулах техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулан Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар 2022 оны 09 дүгээр сарын 01-ний өдөр хэлэлцүүлэн зөвлөлийн гишүүдээс гарсан саналыг тусган Барилга, хот байгуулалтын яаманд 2022 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн 1/1869 дугаар албан бичгээр хүргүүлсэн.</p> <p>Газрын мониторингийн үндэсний сүлжээг өргөжүүлж, бусад байгууллагатай хамтран дундын мэдээллийн сан үүсгэх салбар дундын оролцоог хангах хэлэлцүүлгийг 2022 оны 09 дүгээр сарын 22-ны өдөр зохион байгуулж, холбогдох байгууллагуудаас гарах мэдээллүүдийг нэгтгэн цаашид нэгдсэн дундын мэдээллийн санг үүсгэж мэдээлэл солилцох, холбох ажлыг хэрэгжүүлэхээр Барилга, хот байгуулалтын дэд сайдаар ахлуулсан ажлын хэсгийн тушаалын төслийг боловсруулан, саналаа 2022.12.02-ны өдрийн 01/2272 тоот албан бичгээр Барилга, хот байгуулалтын яаманд хүргүүлсэн.</p> <p>Газар ашиглалт, газрын мониторингийн байнгын ажиллагаатай хяналтын системийг бий болгож, газрыг хамгаалах, нөхөн сэргээх тогтолцоог бүрдүүлэх зорилгоор “Газрын мониторингийн цахим системд шаардлагатай нэмэлт хөгжүүлэлт хийх” ажлыг “Софт матер” ХХК-тай гэрээ байгуулан 2022 оны 09 дүгээр сараас нэмэлт хөгжүүлэлт хийж 12 дугаар сарын 20-ны дотор хүлээж авахаар ажиллаж байна.</p>	
6.1.8	ЗГҮАХ-3.6.1	“Богдхан төмөр зам” төслийн техник, эдийн засгийн үндэслэл, судалгаа, зураг төслийг гүйцэтгэх		Техник, эдийн засгийн үндэслэл, зураг төслийг дуусгана.	<p>Нийслэлийн Сонгинохайрхан, Хан-Уул дүүрэг, Төв аймгийн Алтанбулаг, Сэргэлэн, Баян сумын нутаг дэвсгэрээр дайран өнгөрөх Рашаант-Мааньт чиглэлийн Богдхан төмөр замын зурвас газарт иргэн, хуулийн этгээдийн эзэмшил, өмчлөл, ашиглалтад олгосон нийт 798,8 га талбай бүхий 749 нэгж талбар өртөж байгаа бөгөөд урьдчилсан байдлаар 71 тэрбум төгрөгний нөхөн олговрын тооцоог гаргаж газар чөлөөлөлтийг шийдвэрлэх үүрэг бүхий ажлын хэсэгт танилцуулсан.</p> <p>Засгийн газрын 2022 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 51 дүгээр тогтоолоор Төмөр замын шугамын чигийг тогтоосон. Тогтоолд заасны дагуу батлагдсан чигийн дагуу ашигт малтмалын тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбай болон давхцсан газрыг чөлөөлөх, шинээр газар олгохгүй байх зорилгоор Газрын кадастрын мэдээллийн санд төмөр замын чиг солбицолыг бүртгэж, шинээр газар олгох асуудлыг тухайн зурвас газарт зогсоосон.</p> <p>Богдхан төмөр замын төслийг эрчимжүүлэх талаар Барилга, хот байгуулалтын яам, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар болон Богд төмөр замын төслийг хэрэгжүүлэгч нарын хамтарсан уулзалтыг 2022 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр зохион байгуулсан.</p> <p>2022 оны 06 дугаар сарын 07-ны өдрөөс 06 дугаар сарын 10-ны өдөр хүртэл Богдхан төмөр замын трассын дагуу холбогдох байгууллагуудтай хамтран газар дээр нь ажилласан.</p> <p>ЗТХЯ-наас 2022 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн 3/4323 дугаартай албан бичгээр Богдхан төмөр замын чигийн дагуух зурвас газрыг улсын тусгай хэрэгцээнд авах солбицол тодорхой болж саналаа ирүүлсэн бөгөөд “Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах, гаргах, түүний хэмжээ, заагийг тогтоох, ашиглах журам”-ын дагуу бэлтгэл ажлыг хангаж уг журмын 3.9.7-д заасны дагуу Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Төв аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын саналыг авахаар 2022 оны 1/1886 дугаартай албан бичгээр хүргүүлэн ажилласан.</p>	100
6.1.13	МУТЖҮЧ-9.5.1, 4.2.9, 8.1.3, 9.5.5, ЗГҮАХ-	“Шинэ Зуунмод” хотын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг батлуулж, үе шаттайгаар хэрэгжүүлэх	Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж Засгийн газрын 2019 оны 29 дүгээр	Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, инженерийн дэд бүтцийн зураг төслийг боловсруулсан	<p>Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн 143 дугаар тогтоолоор “Шинэ Зуунмод” хотын хөгжлийн төлөвлөгөө батлагдсан. Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу “Орон сууц олон нийтийн бүс”, “Сургалт-Эрдэм шинжилгээ-Үйлдвэрлэлийн цогцолбор”, Тээвэр логистик, эдийн засгийн чөлөөт бүс”-ийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлыг “Хот төлөвлөлт судалгааны институт”, “Некст степ инженеринг” ХХК болон “Нарт дизайн” ХХК-ууд гүйцэтгэж төслийн ажлын явцыг танилцуулах</p>	100

	3.7.7, 3.3.12, 3.6.1, 3.6.3		тогтоолоор баталсан.	байна.	<p>уулзалт 2022 оны 08 дугаар сарын 30-ны өдөр зохион байгуулсан. Газар чөлөөлөх, нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөө боловсруулах арга зүй болон Хөшигийн хөндийн хот суурины дахин төлөвлөлтийн газар чөлөөлөх бэлтгэл ажлыг хангах чиг үүрэг бүхий зөвлөхийн багтай төлөвлөлтийн уялдаа холбоог сайжруулах үүрэг, чиглэл өгч зөвлөх багуудад шаардлагатай газар эзэмшигч, үл хөдлөх эд, хөрөнгө өмчлөгчдийн болон төлөвлөлт хийж байгаа газрын мэдээллүүдийг харилцан солилцох ажлыг зохион байгуулсан.</p> <p>Шинэ Зуунмод хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу боловсруулагдсан эхний ээлжийн инженерийн хангамжийн гол магистрал шугам сүлжээний ажлын зураг, төслийн дагуу цахилгаан, холбоо дохиолол, ус хангамж, ариутгах татуурга, дулааны шугам сүлжээний барилга, байгууламж, үерийн уснаас хамгаалах үндсэн далан, сувгийн байгууламжийн трассыг “Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим систем”-д оруулж бүртгэлжүүлсэн.</p>	
--	-----------------------------------	--	-------------------------	--------	--	--